



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 97,374,590.05 (ерэн долоон сая гурван зуун далан дөрвөн мянга таван зуун ерэн төгрөг таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал М.Энх-Амар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001482
15-1 huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, Ашиглалтанд он	Тоо ширхэг	Явсан км гүйлт	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Худалдах доод үнэ
							(төгрөг)	
1	Тарилга тээврийн машин Зил-130 (путик-дулаалгатай)	22-88 УБЭ	P3370002	1993/2008	1	549,175	28,076,909.09	3,000,000.00
2	Чиргүүл (путик-дулаалгатай)	22-88 УБЭ	*	1993/2008	1	549,175	6,836,925.91	1,500,000.00
3	Универсал трактор	26-60 УБ	677314	1986/1999	1	16,490	16,500,000.00	2,000,000.00
4	Киа Спортейдж	52-47 УНЭ	KNAJE5528875 01320	2005/2008	1	660,897	31,682,977.27	3,500,000.00
5	Автобус Хьюндай Super-Aerocity	24-72 УБТ	KMJTG18BPRC 007283	2010/2010	1	92,570	14,277,777.78	3,500,000.00
Нийт дүн							97,374,590.05 (ерэн долоон сая гурван зуун далан дөрвөн мянга таван зуун ерэн төгрөг таван мөнгө)	13,500,000.00 (арван гурван сая таван зуу)